

**ТӨРИЙН АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЯЗГААРЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН  
ТӨСӨЛ БОЛОН ТӨРИЙН АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЯЗГААРЛАХ  
ТУХАЙ ХУУЛЬ БАТЛАГДСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ ЗАРИМ АРГА  
ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙГ  
ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ АСУУДЛААР ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН  
ХОРООНООС ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2014 оны 10 дугаар  
сарын 22-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын  
гишүүн С.Дэмбэрэл**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2014 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрийн аж ахуйн үйл ажиллагааг хязгаарлах тухай хуулийн төсөл болон төрийн аж ахуйн үйл ажиллагааг хязгаарлах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Эдийн засгийн байнгын хороо 2014 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Том төрөөс ухаалаг төр рүү” санаачлагын хүрээнд эдийн засгийг идэвхжүүлэх, өсөлтийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэл, хувийн хэвшлийг дэмжих зорилгоор уг хууль, тогтоолын төслийг боловсруулжээ.

Дээр дурьдсан хууль, тогтоолын төслийг хэлэлцэх явцад Улсын Их Хурлын гишүүн А.Тлейхан төр аж ахуйн үйл ажиллагаанаас хол байх гэсэн үндсэн зарчмыг дэмжиж байгаа боловч Төрийн аж ахуйн үйл ажиллагааны тухай хуулийн төслөө нэг мөр оруулж хэлэлцүүлэх, гишүүн Л.Энх-Амгалан бие даасан ийм хууль гаргалгүйгээр өмнө нь Улсын Их Хурлаас батлан гаргасан Эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай тогтоолын хавсралтад заасан арга хэмжээний хүрээнд Өмчлөх эрхийн тухай хуулийн төсөл болон Төрийн өмчийг 2014-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл бодлоготой уялдуулан хамтад нь хэлэлцэх, гишүүн С.Одонтуяа Төрийн өмчийн тухай хуулийн төслийг нэр бүхий гишүүд санаачлаад өргөн мэдүүлэхээр бэлдэж байгаа бөгөөд энэхүү хуулийн төсөлтэй хамтатган хэлэлцэх, гишүүн С.Дэмбэрэл хуулийн төслийн заалтуудыг нарийвчлан анхаарах тухайлбал, төслийн Үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн бодлогыг хэрэгжүүлэх гэсэн заалтаар төрийн болон төрийн өмчит аж ахуйн нэгжийг олноор байгуулаад байж болох талтайг анхаарах, төсөлд орон нутгийн өмчөөр байгуулсан аж ахуйн нэгжийг мөн адил хамруулах, гишүүн Ө.Энхтүвшин Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Азийн хөгжлийн банкттай хамтран 2000-2004 онд сайн засаглалын хөтөлбөрийг боловсруулж, төрийн зайлшгүй хийх, төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлж болох ажил үүргийн жагсаалт гаргаж байсныг анхаарч төсөлтэй уялдуулах зэрэг саналуудыг гаргаж байсан болно.

Төрийн аж ахуйн үйл ажиллагааг хязгаарлах тухай хуулийн төсөл болон төрийн аж ахуйн үйл ажиллагааг хязгаарлах тухай хууль батлагдсантай


холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг тус Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төрийн аж ахуйн үйл ажиллагааг хязгаарлах тухай хуулийн төсөл болон төрийн аж ахуйн үйл ажиллагааг хязгаарлах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудлаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА**



**Б.ГАРАМГАЙБААТАР**